

СОНГОГЧДЫН УЛС ТӨРИЙН ҮЙЛ БАЙДЛЫГ СУДЛАХ ОНОЛ, АРГА ЗҮЙН АСУУДАЛД

Ц.БАТБОЛД

*МУИС. Улс төр судлалын тэнхимийн
дэд профессор, доктор*

Ц.ГАЛСАНДОНДОГ

Улс төр судлалын тэнхимийн докторант

Түлхүүр үг: Улс төрийн сонгууль, сонгогчид, сонгогчдын үйл байдал, зан үйл, абсентизм, онолын сэтгэлгээ, үйл байдлын онолууд, онолын хандлагууд

Товч агуулга: Уг өгүүлэлд сонгогчдын үйл байдлыг судлах онолын хандлагуудыг товч авч үзсэн. Үйл байдлын онолууд: бодлоготой үйлдэл ба хувийн зан үйлийн онол, өөрчлөлтийн үе шатны онол, нийгмийн танин мэдэхүйн онол, нийгмийн сүлжээ ба нийгмийн дэмжлэгийн онол, микро социологи болон макро социологийн тайлбар, нийгэм-сэтгэлзүйн хандлага, рационал сонголтын хандлага зэргийг судлан хэрхэн сонгогчдын улс төрийн үйл байдлыг судалдагыг тодруулах зорилго тавьсан.

* * *

Сонгогчдын үйл байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах хандлага анх 1940 оны сонгуулийн үеэр орон нутгийн хэмжээнд хийгдэж эхэлжээ. 1948 онд Мичиганы их сургуулийн А.Кэмпбэлл, Ф.Конверс, В.Миллер, Д.Стокис нарын эрдэмтэд удирдан нийт улс орныг хамарсан сонгуулийн судалгаа хийсэн нь АНУ-д үндэсний хэмжээний анхны судалгаа болж чадсан юм. 1960-аад оны эхэн үеэс Өрнийн хэд хэдэн оронд том хэмжээний цуврал судалгаа явуулах болсон ажээ. Энэ үеэс хойшхи өнгөрсөн хугацаанд судалгааны ихээхэн баримт, материал цугларсны зэрэгцээ судалгааны онол, арга зүй, аргачлал нь улам боловсронгуй болсоор иржээ.

Өнөө үед сонгогчдын үйл байдлыг судлах судалгааны олон хандлагууд бий болжээ. Засгийн эрх баригчид, иргэд болон нийгмийн бусад субъектүүдийн хоорондын харилцааны асуудал нь эртнээс улс төрийн сэтгэгчид, философичдын анхаарлын төвд байсан билээ. Тухайлбал, “эртний Хятадын сэтгэгч Күнз эзэн хаан ба удирдагчдын хоорондын харилцааны талаар “Удирдагч хүн сайн санаат хүмүүсийн ухамсарт нь нөлөөлбөл хүн бүр түвшин амгалан байж, ухамсартай аж төрнө” гэж үзсэн байна. Ийнхүү Күнз хүний үйл байдалд удирдагчдын зүгээс нөлөөлөхийн чухлыг онцолсон нь өнөөгийн ойлголтоор бол улс төрийн институтын зүгээс олон түмний санаа бодолд нөлөөлөх үйл ажиллагаа юм¹. Эртний Грекийн сэтгэгч Аристотель анх удаа нийгэм дэх харилцаа, түүний дотор улс төрийн харилцааны талаар авч үзсэн билээ. Тэрбээр “Улс төр” бүтээлдээ “бидний харахад аливаа улс нь нэгэн төрлийн харилцаа бөгөөд аливаа харилцаа нь ямар нэгэн ач тусын тулд байгуулагдах учраас бүхий л харилцаа нь аль нэгэн ач тусад тэмүүлэх бөгөөд тэгэхдээ бусад бүх харилцааг өөртөө багтаах тэр харилцаа л хамгийн дээд ач тусад бүхнээс илүү тэмүүлэх болно. Энэхүү харилцааг хүн ба улс төрийн харилцаа гэнэ хэмээн тодорхойлсон байдаг”². Төр улс бол хүмүүс сайхан амьдрахын тулд хоорондоо тогтоож буй харьцахуйн хамгийн дээд хэлбэр, өөрөөр хэлбэл, тийм зорилго бүхий зохион байгуулалтын дээд хэлбэр юм, харин төрийн байгууламж бол энэ харьцахуйг удирдан хэрэгжүүлэхэд зориулагдсан албан тушаалуудын цогцолбор, эл цогцолборыг бий болгох арга, ур чадварын нийлбэр юм³ гэж хүний улс төрийн харилцааны мөн чанарыг тодорхойлсон байна. Аристотелийн энэхүү тодорхойлолтоос үзэхэд улс төрийн бодлогыг хүмүүс хоорондын, улс төрийн институт ба иргэд хоорондын харилцаан дээр тулгуурлан тайлбарласан байна.

Дундад зууны сэтгэгч Фома Аквинский шашин, философийн бүтээлүүддээ бурхнаас тогтоосон хүний харилцааны янз бүрийн хэлбэрүүдийг авч үзсэн байдаг. Тэрээр засаглалын мөн чанар нь захирагч захирагдагч хоёрын харилцааны дэг журам болох тухай, бурхны гаргасан хуулийг хүмүүс нийгэмтэйгээ болон хоорондоо харилцахдаа хэрэгжүүлдэг тухай дурьдсан байна. Дахин сэргэлтийн үед улс төрийн харилцааны талаар

¹ Ц.Мөнхцэцэг. Сонгуулийн кампанийн коммуникаци (Монгол улсын жишээн дээр). УБ., 2009. 13 дахь тал

² Аристотель. Улс төр. Орчуулсан Б.Даш-Ёндон. УБ., 2006. 36 дахь тал

³ Аристотель. Улс төр. Орчуулсан Б.Даш-Ёндон. УБ., 2006. 4 дэх тал

үндэслэл бүхий үзэл баримтлал дэвшүүлсэн хүн бол Н.Макиавелли юм. “Эзэн хаан”⁴ зохиолдоо Макиавелли хүмүүсийн үйл байдал, сэтгэл санааг хэрхэн өөрчлөх, удирдах талаар дэлгэрэнгүй авч үзсэн юм. Дээр дурьдсан Эртний үеэс эхлэн Дундад зуун, Сэргэн мандлын үе хүртэлх сэтгэгчдийн нийгэм-филозофийн сургаал дахь улс төрийн харилцааны талаарх үзэл баримтлалыг хоёр үндсэн чиглэлд хувааж болох юм. Үүнд

- Иргэдийн үйл байдал, ухамсарт нөлөөлөх хэрэгсэл гэж үзэх хандлага. (Күнзийн “Бодрол бясалгал”, Платоны “Төр”, Н.Макиавелли “Эзэн хаан”)
- Хүнийг мөн чанарын хувьд “нийгмийн амьтан”, “улс төрийн шинжтэй” хэмээн үзэж улс төр бол “харилцаа” юм хэмээх хандлага. (Аристотелийн “Улс төр”, Цицероны “Төрийн тухай”, Фомма Аквинскийн “Теологийн нийлбэр”)

XVII зуунаас эхлэн ертөнцийг үзэх үзэлд шинжлэх ухааны нөлөө хүчтэй болсны зэрэгцээ бүгд найрамдах засаг байгуулагдаж эхэлсэн тул сэтгэгчид төр ба иргэдийн хоорондын харилцааг цоо шинээр авч үзэх болсон билээ. Т.Гоббс “Левнафан” зохиолдоо хүний харилцааны мөн чанар бол түрэмгийлэл учраас төр энэ харилцааг зохицуулах ёстой, хүн хүндээ “чоно” байдаг гэж үзсэн бол Ш.Монтескье “Хуулийн амин сүнс” бүтээлүүддээ нийгэм дэх харилцааг зохицуулагч гол механизм бол хууль ёс гэсэн нь буй.

XIX зуун улс төрийн харилцаа, оролцооны онолын хөгжилд томоохон дэвшил авчирсан юм. Урьд өмнө үеийн сэтгэгчид улс төрийн харилцааг удирдагчийн зүгээс олон түмэн рүү чиглэсэн нэг талын, нэг урсгал үйл ажиллагаа гэж үзэж байсан бол М.Вебер, К.Маннхайм, Т.Парсонс нарын нэрт социологичид улс төрийн харилцааг удирдагч ба удирдуулагчдын хоорондын харилцан үйлчлэл гэсэн утгаар тайлбарласан байна. Улс төрийн харилцааг ингэж тайлбарлах нь ихэнхдээ бихеворист (англи хэлний behavior- үйл байдал, зан байдал хандлагтай холбоотой. Энэ хандлага нь засаглалыг, зарим хүмүүс тушаадаг бол нөгөө хэсэг нь захирагддаг үйл байдлын өвөрмөц хэв маяг хэмээн үздэг. Бихеворист тодорхойлолт засаглалыг, түүнд оролцог субъектүүдийн хоорондын харилцааны мөн чанарыг нэг бүрчилсэн шинжтэй болгож, бодит хүмүүсийн харилцан үйлдэл, авч үздэг бөгөөд засаглалын сэдэл шалтгаанд онцгой анхаардаг тал бий. Энэ нь улс төрийн харилцаан оролцож буй хүмүүсийн зан үйлийн шинж байдал улс төрийн мөн чанарыг илэрхийлдэг гэсэн Аристотелийн үзэл санаагаас эхтэй юм.

Америкийн нэрт судлаач Г.Лассуэль засаглалын хамгийн түгээмэл тодорхойлолтыг өгсөн байдаг. Тэрээ “хүнд угаас засаглал руу тэмүүлдэг чанар байдаг. Иймд засаглал бол баялаг, нэр хүнд, эрх мэдэл, эрх чөлөө зэргийг олж авч улмаар амьдралаа сайжруулах арга хэрэгсэл мөн”⁵ хэмээн тодорхойлсон байдаг.

Ийнхүү улс төрийн харилцааны талаарх онолын мэдлэг эрт үеэс хөгжин төлөвшсөн билээ. Харин улс төрийн харилцаан дахь оролцооны онол арга зүй орчин үеийн утгаараа бүрэлдэн төлөвшсөн үе нь XX зуун дунд үе юм. Дэлхийн II дайны дараа улс орнуудын нийгэм соёлын амьдралд гарсан томоохон үйл явц болох хэвлэл мэдээллийн салбарын хөгжил, тэр дундаа телевизийн зүгээс улс төрийн үйл явц, сонгуулийн үйлдэл дүнд үзүүлэх нөлөөлөл хүчтэй болсон билээ. Тийм учраас олон түмний улс төрийн үйл байдал, санал өгөлт, сонгуулийн үр дүн, засгийн газрын легитимт байдлыг судлахын тулд сонгогчдын улс төрийн үйл байдал түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг зайлшгүй авч үзэх шаардлагатай болсон юм. Эдгээр хүчин зүйлсийн үйлдэл дүнд сонгогч иргэдийн улс төрийн үйл байдлын судалгаа эрчимжиж улс төр судлал, социологийн шинжлэх ухааны зааг дээр сонгогчийн улс төрийн үйл байдлыг судалдаг тусгайлсан чиглэл болон хөгжиж байна.

Төлөөллийн ардчиллын суурь, амин чухал асуудал нь иргэд өөрийн ирээдүйн төлөө шийдвэр гаргах үйл явцад шууд оролцож санал өгөх, төрийг байгуулах үйл хэрэгт сонгуулиар дамжуулж оролцох явдал байдаг. Сонгууль улс төрийн үйл явц учраас түүнд оролцох, хандах иргэдийн үнэлэмжийг судалж шинжлэх буюу сонгогчийн улс төрийн үйл байдлын судалгаа бол улс төрийн шинжлэх ухаан дахь судалгаа, шинжилгээний бие даасан хүрээ юм.

Үйл байдал хэмээх үгийг монгол хэлэнд янз бүрийн утгаар хэрэглэж ойлгодог байдал байсаар байна. Улс төр судлал, эдийн засаг, кибернетик, философи, сэтгэл судлал зэрэг шинжлэх ухаанд үйл байдал гэсэн ойлголтыг өөр хоорондоо ялгаатайгаар хэрэглэдэг. Үүнийг тухайн шинжлэх ухааны аспекттай, цаашилбал судлаачдын өөрсдийн үзэл баримтлалын ялгаатай байдалтай холбон тайлбарлаж байна. Жишээлбэл кибернетикийн шинжлэх ухаанд үйл байдал гэдэг үг нь системүүдийн хандлага, төлөв байдал гэсэн утгыг илэрхийлдэг бол харин улс төр судлалд “сонгогчийн үйл байдал, үйл хөдлөл” гэсэн утгаар судалж, хэрэглэсэн байдаг. Харин сэтгэл судлал, анагаах ухааны шинжлэх ухаанд дээрх нэр томъёог үйл байдал гэхээс илүүтэй зан үйл гэдэг агуулгаар хэрэглэж заншсан байна. Тэрээр зан үйл гэдэг нь “бодитоор хийж буй үйлдэл”⁷ юм гэж үздэг. Өөрөөр хэлбэл зан үйл гэдэг нь салангид үйлдлүүдийн нэгдэл байдаг гээд зан үйлийг тодорхойлогч гэдэг нь тухайн үйлдлийг хийх эсэхэд нөлөөлж буй хүчин зүйлс юм. Үүнийг зуучлан холбогч хүчин зүйлс

⁴ Н.Макиавелли. Эзэн хаан. Орчуулсан Д.Ганбат. УБ., 2011 он

⁵ Ш.Л.Монтескье. Хуулийн амин сүнс. Орчуулсан. Т.Төмөрхүлэг. УБ., 2008 он

⁶ Улс төрийн шинжлэх ухаан. МУИС. Хамтын бүтээл. УБ., 2014. 109 дэх тал

⁷ Мира Б. Аги, Рейчел Карнийж. Зан үйлийн төлөвшил ба хүмүүсийн оролцоо. УБ., 2008. 27 дахь тал

ч гэж нэрлэдэг байна. Энэхүү зуучлагч хүчин зүйлсд дотоод (санаа зоволт, итгэл үнэмшил) болон гадаад (нийгмийн харилцааны орчин, дэмжлэг, эсэргүүцэл г.м) хүчин зүйлс ордог байна⁸. Я.Цэвэлийн Монгол хэлний товч тайлбар толь бичигт “зан үйл гэдэг нь ямар нэгэн нийгэмлэгийн (нийгмийн Д.Г.) шаардлагад тохирох хүний ааль, авир, дүрэм, төлөвийг хэлнэ”⁹ гэжээ.

Хүснэгт 1.

Хүний зан үйлийн талаар онолын ухагдахууны загвар¹⁰

Өөрчлөлтийн түвшин	Өөрчлөлтийн үйл явц	Онол ба загвар	Зорилтот бүлэг	Стратеги ба ур чадвар
Хувь хүний	Сэтгэл зүйн	Үнэт зүйлсийг хүсэн хүлээх Хандлагын өөрчлөлт Хяналтын онол Зан чанарын онол Хамаарлын онол	Хувь хүний зан үйл Хөгжлийн үйл явц Мэдлэг Хандлага Үнэт зүйлс Ур чадвар Өөртөө итгэх итгэл Өөрийгөө хүндлэх	Хөтөлбөр, хэрэгжилт Боловсролын түвшин Олон нийтийн хэвлэл мэдээлэл Нийгмийн маркетинг Чадвар хөгжүүлэх Амьдрах ухаан
Хүн хоорондын	Нийгэм-сэтгэл зүйн	Сүлжээний онол Нийгмээс суралцах онол Нийгмийн дэмжлэгийн онол Үүргийн онол Нийгмийн харьцуулалтын онол	Хүн хоорондын зан үйл Нийгмийн сүлжээ Нийгмийн дэмжлэг Гэр бүл Үе тэнгийнхэн Хөршүүд Хамтран ажиллагч бүлгүүд	Нийгмийн сүлжээ өргөсөх Гэр бүлийн зөвлөгөө, дэмжлэг Нийгмийн дэмжлэгийн бүлгүүд Норматив бүлгүүд илүү хүрч ажиллах Үе тэнгийн нөлөө, зөвлөгөө
Олон нийтийн	Соёл заншил ба нийгмийн	Соёл заншлын өөрчлөлтийн онол Нийгмийн өөрчлөлтийн онол Олон нийтийн хөгжил Шинэ мэдлэг, ойлголт тархах онол Олон нийтийн эрх мэдэл Олон нийтээр шийдвэр гаргах	Бүлгийн зан үйл Бүс нутгийн эдийн засаг Олон нийтийн нооц боломж Хөрш зэргэлдээ байгууллагууд Байгууллагын харилцаа Ардын уламжлалт зан үйл Засгийн газрын бүтэц Албан ёсны удирдлага Албан бус удирдлага	Өөрчлөлтийн хүчин зүйлс Олон нийтийн хөгжил Олон нийтийн эвсэл холбоо Чадавхижуулах Оролцооны арга зүй Зөрчлийг шийдвэрлэх стратеги Олон нийтийн хэвлэл мэдээлэл

Эдгээр онол загварууд нь зан үйлийн хөгжил, өөрчлөлтөнд хүргэх өөр өөр арга замуудыг тайлбарласан. Мөн хувь хүний өөрчлөгдөх үйл явцыг эдгээр онолууд эхлээд тайлбарласан төдийгүй өөрчлөлтийн үйл явц хэнд чиглэхийг буюу тухайн зан үйлийг эзэмших нийгмийн нэгжийг өөрчлөлтийн үе шатуудаар тодорхойлсон байдаг. Эдгээр онолууд нь хэнийг өөрчлөхийг зорьж байгаа, өөрчлөлтийн ямар явцад ямар стратеги, ур чадвар шаардагдах зэргээр өөр хоорондоо ялгаатай. Бүх онол загварууд нь хүмүүсийн зан үйл хэрхэн төлөвшин хөгждөг талаар тайлбарлахыг хичээдэг бөгөөд ямар үйл ажиллагаа явуулбал илүү үр дүнтэй болохыг тодорхойлохыг зорьдог. Онол тус бүр зан үйлийн өөрчлөлтийн үйл явцын ерөнхий дүр зургийг харуулснаараа хувь хүн, олон нийт, нийгмийн зан үйлд нөлөөлөхийг зорьж буй хөгжлийн хөтөлбөрүүдэд чухал ач холбогдолтой байдаг. Дүгнэж хэлэхэд зан үйлийн онолууд нь дараах дөрвөн чухал асуултанд хариулт өгсөнөөрөө хувь хүний хөгжлийг чиглүүлэгч болж чаддаг байна.

Юуг? Ямар зан үйл, үйлдэл, дадал зуршлыг эзэмшүүлэхийг зорьж байгаа

Яагаад? Тухайн зан үйлийг эзэмшихэд нөлөөлдөг шалтгаан, хүчин зүйлс

Хэзээ? Үйл ажиллагааг зөв цагт, зөв дарааллаар хэрэгжүүлэх

Яаж? Зан үйлийн өөрчлөлтийг ямар арга замаар бий болгох зэрэг асуудал юм. Хэрэв

эдгээр дөрвөн асуултанд хариулт өгч чадах түвшинд хувь хүн өөрийн зан үйлээ чиглүүлж чадаж байвал аливаад хандах зөв хандлагыг төлөвшүүлж байна гэж үздэг. Ингээд хувь хүний зан үйлийн талаар Өрнийн орнуудад түгээмэл дэлгэрсэн зарим онолуудаас авч үзье.

⁸ Мөн тэнд

⁹ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 2013. 371 дэх тал

¹⁰ Мира Б. Аги, Рейчел Карнийж. Зан үйлийн төлөвшил ба хүмүүсийн оролцоо. УБ., 2008. 28 дахь тал

1. *Бодлоготой үйлдэл ба хувийн зан үйлийн онол.* Энэхүү онол хүний зан үйлийг тодорхойлогч гол хүчин зүйл нь хүний бодол санаа, ойлголт, итгэл үнэмшил гэж үздэг. Судлаач Фишбейн, Азжен нарын боловсруулсан энэ онол нь зан үйлийн талаарх ойлголт ухагдахууныг *зан үйлийн санаа зорилго* (behavioral intent) гэсэн ойлголтоор баяжуулсан юм. Судалгаа явуулсны үр дүнд тэд хувь хүн аливаа зан үйлийг үйлдэх эсэхийг тодорхойлогч гол хүчин зүйл нь зан үйлийн санаа зорилго юм¹¹ гэсэн дүгнэлтийг гаргажээ. Зан үйлийн санаа зорилго нь тухайн хувь хүний эерэг зан үйлийг төлөвшүүлэхэд шаардлагтай тууштай хүсэл эрмэлзлэлийн түвшин болон тухайн зан үйлийг үйлдэх магадлалын түвшинг харуулдаг. Зан үйлийн санаа зорилгод дараах зүйлс нөлөөлдөг байна. Үүнд,

- Хувийн хандлага-тухайн зан үйлийг сайн, муу талаас нь харах хувь хүний итгэл үнэмшил ба үүнийг үйлдэх хэрэгтэй эсэх талаар хувийн үзэл бодлын хослол юм. Энэ нь тухайн үйлдлээс сайн үр дүнд (таатай хандлага), эсвэл муу үр дагавар (таагүй хандлага) гарна гэсэн хувийн итгэл үнэмшил дээр тулгуурладаг.
- Нийгмийн зүгээс ирэх нөлөөлөл. Үүний үр дүнд үүссэн хувь хүний сэтгэл зүйн төлөв хандлага үнэлэмжийг үйл байдал гэдэг утгаар авч үзвэл илүү оновчтой гэж үзэж буй болно. Энэ нөлөөлөл нь нийгмийн зүгээс ирэх шахалт, дарамт болон тухайн хүний хүрээлэл (гэр бүл, найз нөхөд, хамт олон, нийгмийн бүлэг гэх мэт)-д үйлчилж нийгмийн шинжтэй үйл байдлын хэв загварыг бүрэлдүүлж байдаг.

Бодлоготой үйлдлийн онолын сүүлийн үеийн загвар нь үйл байдлын нөлөөллийн талаарх ойлголт (perceived behavioural control) шинээр гаргаж ирсэн юм. Бие хүн өөрөө хянан захирах боломжгүй гадны хүчин зүйлс ч мөн тухайн үйл байдлыг хэрэгжүүлэх эсэхэд нөлөөлдөг гэдгийг энэ ухагдахуунаар тайлбарладаг. Тодруулж хэлбэл, дараах байдлаар илэрхийлэгдэнэ.

Үйл байдлын нөлөөллийн талаарх ойлголт-тухайн зан үйлийг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөц боломж болон тулгарах саад бэрхшээлийн талаар хувь хүний ойлголт болон тэдгээр нь уг үйл байдлыг хэрэгжүүлэхэд эерэг ба сөргөөр хэрхэн нөлөөлөх тухай төсөөлөл юм. Үйл байдал бүрэлдэн төлөвших үйл явцад хувь хүний хандлага, хэм хэмжээ, зан үйлийн санаа зорилго, нөлөөллийн талаарх ойлголтууд хөдөлгөх хүч болж сэдэл болж өгдөг гэдгийг энэ онол хүлээн зөвшөөрдөг. Мөн нөлөөллийн талаарх ойлголт нь үйл байдлын санаа зорилготой адилаар хувь хүний хийх үйлдэлд шууд нөлөөлдөг гэдгийг энэ онол тодотгодог. Гэхдээ эдгээр хүчин зүйлсийн ач холбогдол нь үйл байдлын зорилгоос өөрөөс нь хамаардаг байна. Тухайн үйл байдлын талаар өөрөө таатай хандлагатай байгаа бөгөөд нөлөө бүхий хүмүүс нь ч уг зан үйлийг хэрэгжүүлэх оролдлого гаргадаг гэж хувийн зан үйлийн онолд үздэг. Зарим хүмүүсийн хувьд уг шийдвэрийг гаргахад нийгмийн шахалт нөлөөнөөс илүү хувийн хандлага нь чухал байр суурь эзэлдэг байхад заримынх нь хувьд энэ нь эсрэгээр байдаг. Жишээ нь, хүний үйл байдлыг угсаатны зүйн талаас нь судалсан судалгааны хүрээнд (санамсаргүй түүврийн аргаар тухайлсан асуудлыг сайн мэддэг 30 хүртэлх экспертээс авсан судалгаа) өөрсдийн үйл байдлыг хэрхэн үздэг талаар ярилцсан байна. Ингэхэд “хайрлан хүндэлдэг, шүтэн биширдэг хүмүүсийнхээ өмнө хүн яагаад ерийнхөөсөө өөр байж, өөр үйл байдлын хэв загварт ордог вэ?” гэсэн асуултанд өгсөн тэдний хариулт нь нийгмийн нөлөө шахалт хувийн хандлага болон бие хүний үйл байдал үйлдэлд хэрхэн нөлөө үзүүлдэг талаарх Фишбейний онолыг баталсан дүн гарсан байна. Өөрөөр хэлбэл хүний зан авир, үйл байдал болон тэдний биеэ хэрхэн авч явж, ямар үйл, үйлдэл хийхэд нь бусад хүмүүс нөлөөлж байдаг. Бид өөрсдийн хүндэлж хайрлаж, шүтэн биширдэг хүмүүсийнхээ өмнө байхдаа зан авир, үйлдэл төдийгүй үйл байдлын өөр төлөвт шилждэг. Учир нь бид тэднээс сайшаал магтаал авахыг хүсдэг, тэд бидний талаар сайн сайхнаар бодоосой гэж хүсдэг, мөн тэдний хэлж буй үг, хийж буй үйлдэл бүхэн бидэнд үлгэр дууриал мэт дүр зургийг үлдээдэгт оршино.

2. *Өөрчлөлтийн үе шатны онол.* Энэ онол нь зан үйл (үйл байдал)-ийн өөрчлөлтийг үйл явц талаас нь тайлбарладаг бөгөөд өөрчлөлтийн явцад хүн бүрийг дамждаг сэтгэл зүйн үе шатууд нь ерөнхий хэдэн ижил шинж чанартай гэж үздэг. Хүн бүрийн өөрчлөгдөх сэдэл нь өөр хоорондоо харилцан адилгүй байдаг бөгөөд тэднийг өөрчлөлтийн аль үе шатанд байгаагаас нь хамаарч түүнд нь тохирсон үйл ажиллагаа явуулах ёстой гэсэн онолыг Прочаска 1992 онд боловсруулсан байна. Энэ онолын дагуу зан үйлийн өөрчлөлтийг таван үе шатаар тодорхойлдог. Үүнд,

- Ухаарахаас өмнөх үе- бэрхшээлтэй асуудал байгааг огт мэдэхгүй учир зан үйлээ өөрчлөх талаар огт бодоогүй байгаа үе.
- Ухаарах үе- өөрчлөлтийн талаар бодож эхлэх үе.
- Шийдвэр гаргах үе- зан үйлээ өөрчлөх төлөвлөгөө гаргаж эхлэх үе
- Хэрэгжүүлэх үе- тодорхой төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх үе
- Хэвших үе- шинэ дадал зуршлаа тогтвортой хэвшүүлэх үе.

Эдгээр 5 үе шат нь хүний үйл байдлын бүрэлдэн бий болох үйл явцыг илтгэн харуулдаг байна.

¹¹ Мира Б. Аги, Рейчел Карнийж. Зан үйлийн төлөвшил ба хүмүүсийн оролцоо. УБ., 2008. 32 дахь тал

3. *Нийгмийн танин мэдэхүйн онол.* 1986 онд Альберт Бандурагийн боловсруулсан нийгмийн танин мэдэхүйн онол хувь хүмүүс нийгмийн орчинтойгоо (найз нөхөд, гэр бүл, ажлын хамт олон гэх мэт) тогтмол харилцаанд орж байдаг бөгөөд харилцан бие биедээ нөлөөлдөг гэж үздэг¹². Энэхүү онолын гол санаа нь зан үйл бол хувийн (өөрийн сэтгэл санаа, хариу үйлдэл г.м) ба орчны нөлөө (нөлөө бүхий хүмүүсийн бодол санаа, зөвлөгөө ба сэтгэгдэл г.м) гэсэн хоёр талт хүчин зүйлийн үр дүн гэж үздэг. Өмнө гарсан онол загваруудаас ялгаатай тал нь энэ онол хувь хүний өөрийн туршлага, бусдын ажиглалт ба тэдний үйлдлийн үр дүнд голлон анхаардаг. Нийгмийн танин мэдэхүйн онол нь хүний зан үйлийг олон хэмжээст, хоёр талт үйл явц гэж үздэг. Энэ онол нь хүн хоорондын зан үйлд чиглэсэн хөтөлбөрийг боловсруулахад чиглэл болох дөрвөн ухагдахууныг гаргаж ирсэн. Үүнд,
- Хоёр талт тодорхойлогч хүчин зүйлс-зан үйлийн өөрчлөлт нь хүн болон орчин нөхцлийн хоорондын хоёр чиглэлт харилцааны үр дүн юм.
 - Зан үйлийн чадавх-зан үйлд нөлөөлөх мэдлэг чадвар
 - Хүлээж буй үр дүн-тодорхой зан үйлийг хэрэгжүүлбэл хүссэн үр дүндээ хүрнэ гэсэн итгэл
 - Өөртөө итгэх итгэл-тухайн зан үйлийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагтай чадвар өөрт нь байгаа гэдэгт итгэх итгэл. Тодруулбал, хэрэв хүн тухайн үйлдлийг хийх чадварт өөрт нь байгаа гэдэгт итгэвэл түүнийгээ хийж, хэвшүүлэх магадлал өндөр байдаг гэж нийгмийн танин мэдэхүйн онол үздэг.

Нийгмийн танин мэдэхүйн онол нь хүний үйл байдал нь түүний өөрийн туршлага (оролдлого, алдаа оноо) хийсэн үйлдлийнх нь үр дүн болон бусдаас ажиглан суралцсан зүйлсээс бүрэлдэн бий болдог гэж үздэг. Ажиглалт болон бусдын үр дүнтэй үлгэр дуурайлал нь шинэ зан үйлийг эзэмшихэд чухал үүрэгтэй юм. Ажиглалт судалгаанаас үзэхэд үлгэр дууриал болсон хүн нь тухайн зорилтот бүлгийн хүмүүстэй хэдий чинээ адил байна, түүнийг дуурайх магадлал, хүсэл эрмэлзлэл төдий чинээ илүү байдаг байна. Бандурагийн онол ёсоор хувь хүний өөртөө итгэх итгэл нь аливаа нөхцөл байдлын талаар сэтгэл хөдлөлийн хариу үйлдэл, мэдрэмж нийгмийн орчин дахь нөлөө бүхий хүмүүсийн ятгалга, үзэл бодол урамшуулал зэргээс бүрэлдэн бий болдог байна.

4. *Нийгмийн сүлжээ ба нийгмийн дэмжлэгийн онол.* Энэ онол нь хувь хүний болон хэсэг бүлгийн зан үйлд нийгмийн харилцаа эерэг болон сөргөөр нөлөөлдөг механизмыг тайлбарладаг. Судлаачдын тодорхойлсноор нийгмийн сүлжээ гэдэг нь хүн төвтэй, хүмүүсийн хоорондын хэлхээ холбоо, нийгмийн харилцааны цогц бүрдэл юм. Нийгмийн сүлжээ ба нийгмийн дэмжлэгийн онолоор тухайн нийтлэгт харьяалагдах хүний үйл байдлын хэв маягийг тодорхойлохын тулд нийгмийн сүлжээний дараах шинж чанарыг харгалзан үзэх шаардлагтай юм. Үүнд,
- Тухайн сүлжээн дэх хүмүүсийн тоо, хэмжээ, бүтэц, бүрэлдэхүүн
 - Хоорондын холбоо-хэр ойр дотно байдаг, хэр бат бэх холбоо харилцаатай байдаг эсэх
 - Нягтрал буюу сүлжээн дэх хүмүүс бүгд бие биеэ сайн мэддэг эсэх
 - Харилцан хамаарал буюу сүлжээний гишүүд хоорондоо дэмжлэг өгч, авч чаддаг эсэх. Эдгээр дөрвөн шинж чанар бүрэлдсэнээр аливаа харилцаанд оролцож буй хүн түүний эргэн тойрны хүрээлэлээс авч буй мэдлэг, мэдээлэл нь тухайн хүний үйл байдлыг хадгалах буюу өөрчлөхөд чиглэж байдаг.
5. *Шинэ мэдлэг, ойлголт тархах онол.* Аливаа шинэ зүйл, өөрчлөлтөд хандах олон нийтийн үйл байдлыг судалсны үндсэн дээр Эверест Рожерс шинэ мэдлэг, ойлголт тархах онолын загварыг боловсруулжээ. Хувь хүн болон хэсэг бүлэг хүмүүс аливаа шинэ, өөр санаа бодол, зан үйлийг хэрхэн хүлээн авч байгаагаар нийгмийн өөрчлөлт буюу хүний зан үйлийн өөрчлөлтийг тайлбарлах боломжтой гэж энэ онол үздэг. Хувь хүний болон гэр бүлийн зан үйлд нийгмийн нөлөөний гүйцэтгэх үүргийг ч мөн энэ онол тайлбарладаг. Энэ онолоор шинэ мэдлэг, ойлголт нийгэмд дараах байдлаар тархдаг гэж үздэг. Үүнд 1. Шинэ ойлголт зүйлийн талаар мэдээлэл авах, сонсох. 2. Сонирхох. 3. Турших. 4. Хүлээж авах эс авахаа шийдэх. 5. Өдөр тутмын амьдралынхаа нэг хэсэг болгон хүлээн авах, эсвэл өөрчлөн тохируулж хэрэглэх шатуудыг дамждаг байна. Аливаа шинэ зүйл гэж нэрлэж буй зүйлс маань шинэ технологи, хандлага, арга барил, зан үйл, бодлого, дадал зуршил, хөтөлбөр зэрэг маш өргөн хүрээтэй ойлголтуудаар дамжин хэрэгждэг онцлогтой.

Зан үйлийг тодорхойлогч хоёр гол дотоод хүчин зүйл болох мэдлэг, хандлагын талаар энд дурьдах нь чухал. Хандлага гэдэг нь тухайн бэрхшээл, асуудлын талаарх хувь хүний сэтгэгдэл, санаа бодол буюу баримталж буй зарчим, үнэт зүйлсийн талаарх ойлголт юм. Мэдлэг гэдэг нь шинжлэх ухааны баримт, туршлага, эсвэл уламжлалт итгэл үнэмшлийг өөрийн болгон эзэмшсэн байдлыг хэлнэ. Мэдлэг нь зан үйлийн өөрчлөлтөнд чухал үүрэгтэй боловч дангаараа хангалтгүй гэдэг нь туршлагаас харагддаг. Аливаа мэдлэг объектив агуулгатай байдаг учир түүний хүний сэтгэл зүй, үнэлэмжээс хамаарах хамаарлыг шууд тогтоох боломжгүй байдаг нь шинжлэх ухааны мэдлэгийн онцлог юм. Объектив агуулгатай, баталгаа нотолгоо бүхий үндэслэлтэй,

¹² Мира Б. Аги, Рейчел Карнийж. Зан үйлийн төлөвшил ба хүмүүсийн оролцоо. УБ., 2008. 37 дахь тал

харилцан шүтэлцээ, уялдаа холбоо бүхий мэдлэгийн тогтолцоог бүтээх үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэрийг бол шинжлэх ухаан гэнэ. Шинжлэх ухаан гэж юу вэ гэдгийг тодорхойлохын тулд дараах зүйлсийг харгалзах хэрэгтэй¹³. *Нэгдүгээрт*, шинжлэх ухааны мэдлэг нь тусгайлан боловсруулсан ойлголт, хэллэгүүдээ томъёологдсон нотолгоо, баталгаа бүхий үндэслэл дүгнэлтүүдийн цогцолбор тогтолцоо байдаг. *Хоёрдугаарт*, шинжлэх ухааны мэдлэг нь бодит байдлын юмс үзэгдлийн объектив хууль зүй тогтолуудыг илэрхийлдэг. *Гуравдугаарт*, шинжлэх ухааны мэдлэг нь хэн нэгэн хүний бодрол сэтгэмж бус, нийт хүн төрөлхтөний оюун болон практик үйл ажиллагааны цогц үр дүн байдаг.

Бид асуудлыг аль ч талаас нь авч үзсэн бай судлагдахууны мөн чанар нь нэг талаас хүний дотоод сэтгэл хөдлөл, зан төлөв, авир (зан үйл) нөгөө талаас хүнд нийгмийн орчны зүгээс нөлөөлөх нөлөөллийн үр дүнд бүрэлдэн буй болж байгаа үнэлэмж, үйлдэл (үйл байдал)-ийн цогц утга нь хүний аливаад хандах хандлагыг шинж төлөвийг бүрэлдүүлж байдаг гэдэгтэй хэн ч маргахгүй буй за. Энэ утгаар нь авч үзвэл үйл байдал, зан үйл гэсэн хоёр ойлголтыг нэг утгаар ойлгож, хэрэглэх нь төөрөгдөлд хүргэхгүй бөгөөд улс төрийн шинжлэх ухаанд үйл байдал гэдэг утгаар хэрэглэж заншсан байдлыг харгалзан цаашид “иргэдийн улс төрийн үйл байдал”, “сонгогчийн улс төрийн үйл байдал” гэдэг томъёоллоор хэрэглэж бичих нь зүйтэй хэмээн үзэж болно.

Эдгээр асуултуудад өгч буй хариултууд олон янз бөгөөд асуудлын аль нэг талыг голлосон судалгааны олох хандлагууд бий болж байна. Гэвч иргэдийн улс төрийн үйл байдлын асуудал нь төсөөлж байгаагаас ч илүү нарийн төвөгтэй юм. Энэ нь уг үзэгдлийн өөрийн нь нарийн нийлмэл шинж, түүнийг судлахад хэрэглэж буй аргуудын олон янз хандлагууд, түүнчлэн үндсэн ойлголтын нэр томъёоны тодорхой бус байдалтай холбоотой байна. Ялангуяа улс төрийн шинжлэх ухааны уламжлалт нэр томъёоны тодорхойгүй байдал онцгой хүндрэл учруулж байгаа юм. Учир нь иргэдийн улс төрд хандах үйл байдлыг тодорхойлохдоо улс төрийн оролцоо, улс төрийн идэвхи, санаачлага, улс төрийн үйл ажиллагаа гэсэн ойлголтуудтай хольж хутгах, тэдгээрийг агуулгын ялгааг тодорхой болгох зэрэг цаашид анхаарууштай асуудлууд байсаар байгааг энд дурьдая.

Улс төрд хандах иргэдийн үйл байдал, улс төрийн идэвхийн тухай асуудал эртнээс олон орны судлаачдыг анхаарлыг татсаар ирсэн байна. Өргөн утгаар нь авч үзвэл сонгогчийн үйл байдлын судалгаа ардчилсан нийгэм, түүний системүүд үүргээ хэрхэн биелүүлж, иргэд тэдгээрийг юу гэж ойлгож, тэдгээрт хэрхэн хандаж буйг харуулдаг. Тиймээс сонгогчийн үйл байдлын судалгаа дараах асуултад хариулахаас эхэлдэг. Үүнд Хүмүүс хэнийг сонгодог вэ?, Тэд яагаад сонгодог вэ?, Юуг хүсэж, бодож тэд сонголт хийдэг вэ гэсэн асуултууд юм. Сонгогчдын санал өгч сонголт хийх чадварын тухай асуудал псефологчдын (хүмүүн сонгуульд саналаа хэрхэн өгдөгийг судалдаг салбар) анхаарлыг ямагт татсаар ирсэн асуудлын нэг юм.

Дээр дурьдсан асуултуудад хариулт өгөхийн тулд нийгмийн харилцааны онолын хүрээнд боловсрогдоо бий болсон онол, хандлагуудын хүрээнд асуудлыг авч үзэх нь арга зүйн чухал ач холбогдолтой юм. Сонгогчийн үйл байдлын судалгаа олон жил хөгжихдөө *социологийн, нийгэм-сэтгэл зүйн болон рационал (ухаалаг) сонголтын*¹⁴ гэсэн 3 гол хандлагаар явж иржээ. Социологийн хандлага (С.Липсет, С.Роккан, Паул Ф.Лазерфельд, Ч.Э.Мерриам, Г.Ф.Госнем)-ын чармайлтын үр дүнд сонгогчийн улс төрийн үйл байдлыг түүний харьяалагдаж буй нийгмийн бүлэг болон нийгэмд эзэлж буй байр суурийнх нь онцлогоор гаргаж ирэхэд анхаардаг. Энэ судалгаа сонгогчдын санал өгөлтөд нийгмийн хамаарал шууд нөлөөтэй байдгийг харуулдаг. Сонгогчийн үйл байдлыг судлах социологийн чиг хандлага нь өнгөрсөн зууны 50-иад оноо хөгжсөн бөгөөд сонгогчдын дунд санал асуулга авах замаар социологийн судалгаа явуулж сонгогчийн үйл байдлын төлөвийг судалж гаргадаг онцлогтой. Тоон судалгаан дээр суурилан бие хүний нийгмийн шинж онцлогууд болон түүн дээр үндэслэн сонгогчдын санал өгөх сэдлийн харилцан хамаарлын гаргах замаар шинжилгээ хийнэ гэсэн үг. Ингэхдээ нийгэм, ангийн байдал (зүүн чигийн нам- ажилчин анги, баруун чигийн нам-дунд анги), шашин, үзэл суртал, нийгмийн хувьсагч хүчин зүйлүүд (хүйс, нас, ажил мэргэжил боловсрол, нийгмийн гарал, арьс өнгө, намын харьяалал, орлого, амьжиргааны түвшин гэх мэт)-ийг суурь болгон ашигладаг. Сонгогчийн үйл байдлыг судлах социологийн арга, хандлага нь дотроо микро, макро гэсэн 2 түвшинд хуваагддаг.

Микросоциологийн чиглэлийн тайлбар. Сонгогчдын үйл байдал нь бүлгийн үйл байдал юм. Шинжлэх ухаанд микросоциологийн, социал бүтцийн буюу мөн бүлгийн гэж нэрлэгдэх болсон энэхүү үндэслэлийн эхлэлийг анх Пауль Ф.Лазерфельд болон түүний шавь нар тавьжээ. Тэрээр Колумбийн Их Сургуульд 1940 оны АНУ-д болсон ерөнхийлөгчийн сонгуулийн үеийн санаа бодол бүрэлдэх үйл явцын судалгааг хийсэн байна. Уг судалгаанаас гарсан гол дүгнэл нь тухайн хүний хатуу тогтсон үйл байдлын хэв шинж нь түүний харьяалж буй бүлгийн шинж агуулгатай давхцаж байсныг тогтоосон байна. Нийгэм эдийн засгийн статус шашин шүтлэг, оршин сууж буй хот, суурин газруудын хэмжээ зэрэг тодотголуудын тусламжтайгаар бүлгийн хамаарлыг тогтоох боломжтой байдаг аж. Тухайн сонгогчийн хамаарах бүлгийн сонгуулийн оролцоо жигд

¹³ Г.Лодой. Философи ба шинжлэх ухааны арга зүй. УБ., 2004. 4 дэх тал

¹⁴ International Encyclopedia of Political Science. IPSA., 2012. p. 738

болох тусам хувь хүний гаргасан шийдвэр бүлгийнхээсээ ялгарах магадлал бага байна. Хоорондоо зөрчилтэй хүчин зүйлс давхардаж нэгэн зэрэг сонгогчид шахалт үзүүлбэл ихэвчлэн түүний улс төрийн сонирхол буурч, сонгуульд оролцох оролцоогоо багасгах, санал өгөх шийдвэр гаргахаа хойшлуулдаг. Ингэхээр тухайн хүний улс төрийн санал бодол төлөвшихөд социал хүрээ хүчтэй нөлөө үзүүлдэг болох нь нотлогдож байна. Ийнхүү бие биенийхээ нөлөөллийг харилцан хүчтэй болгож өгдөг социал хүчин зүйлсийг төвд нь тавьж, энэ үүднээсээ сонгогчийн сонгуулийн үеийн тогтвортой бөгөөд удаан хугацааны туршид өөрчлөгддөггүй үйл байдлыг тогтоодог. Энэ үүднээсээ сонгуулийн өмнөхөн сонголтонд нь орсон өөрчлөлтийг тайлбарлахад хүндрэлтэй байдаг. Микро түвшний арга, хандлагын гол санаа нь тухайн сонгогчийн хамаарах бүлгийн сонгуулийн оролцооны хэм хэмжээ нь жигд болох тусам тус бүлэгт хамаарах сонгогчийн гаргасан шийдвэр бүлгийнхээсээ ялгарах магадлал бага байна. Хоорондоо зөрчилтэй хүчин зүйлс нэмэгдэж бүлгийн доторх сонгогчдын байр суурь зөрөх үед тэдний улс төрийн шийдвэр гаргах байдал эрс ялгаатай болох магадлал ихэсдэг гэж үздэг байна. Иймээс ч сонгогчийн улс төрд хандах хандлага, санал бодол төлөвших хийгээд сонгуульд оролцож санал өгөхөд социал хүрээний үзүүлэх нөлөө хүчтэй гэдгийг тэд гол болгодог юм.

Макросоциологийн чиглэлийн тайлбар. Энэ чиглэлийн тайлбар нь Европт XIX зуунаас эхэлсэн хүн амын тодорхой бүлэг болон улс төрийн намуудын хоорондын урт хугацаанд тогтвортой харилцаа холбоог илэрхийлэл болж гарч ирсэн. Улс орнууд дахь сонгуулийн хууль, улс төрийн институциудын хоорондын ялгаанаас үл хамааран улс төрийн намууд өөр өөрийн сонгогчидтой байдаг нийгмийн баазтай холбоотой бий болсон. Өөрөөр хэлбэл макро түвшний арга, хандлага нь төр, улс төрийн намуудын тогтвортой дэмжигчдийн хүрээ, өөрчлөлтийг тандахад чиглэдэг. Энд нийгэм дэх үнэт зүйлсийн эрхэмлэл, намуудад өөрийгөө адилсуулах үйл явц зэрэг хамаардаг.

Харин нийгэм-сэтгэл зүйн хандлага. Сонгогчдын санаа бодол, үйл байдлыг шинжлэх ухааны үндэстэй судлах ажлыг 1950-иад оны Америкийн ерөнхийлөгчийн сонгуулийн үед Мичиганы Их Сургуулийн хэсэг судлаачид (А.Кемпбелл, Ф.Конверс, В.Миллер, Д.Стоке¹⁵, Ж.Еванс¹⁶, Х.Вейсберг¹⁷) нийт улс орныг хамарсан сонгуулийн судалгаа хийжээ. Нийгэм-сэтгэл зүйн хандлагын шинжилгээ нь бие хүний сэтгэл зүйн хандлага нь сонгогчийн сонгуульд сонголт хийж санал өгөх гол үндэс нь болдог талаар дүгнэдэг.

Нийгэм-сэтгэл зүйн хандлага нь сонгогчид руу хандсан улс төрийн нарийн бодлого болон сонгогчдын санаа бодлын тогтворгүй байдлын хоорондын асуудал дээр төвлөрч сонгогчдын сэтгэл зүйн тогтсон хандлага хийгээд ухамсарлагдаагүй харилцаа тэдний сонголт хийх шийдвэрт хэрхэн нөлөөлдөг болохыг тодруулахад чиглэдэг. Тухайлбал, сонгогчдын олонхи нь яагаад нэг нам руу хошуурч саналаа өгдөг вэ?, сонголт хийхэд цаг үеийн нөхцөл, нийгмээс үзүүлж буй дарамт, шахалт эсвэл дэмжлэг хүний сэтгэл зүйд хэрхэн нөлөөлдөг вэ? зэрэг асуултуудад хариулт өгөхөд чиглэдэг. Гэхдээ энэ хандлагын суурь нь улс төрийн нийгэмшилт байдаг. Энд мөн улс төрийн нам, улс төрдийг тууштай дэмжигчдийн идэвхтэй үйл ажиллагаа чухал нөлөө үзүүлдэг.

Хувь хүний сэтгэл зүйг голлосон үндэслэлд нэг талаас хувь хүн, гэр бүл болон нийгмийн нийгэмшүүлэх бүтцүүдээр дамжуулан төлөвшсөн намын ижилслээр илэрхийлсэн улс төрийн санаа бодол бүрэлдэх үйл явцыг онцгойлон үздэг. Нөгөөтэйгүүр социологийн загвартай харьцуулахад сонгуулийн үед шийдвэр гаргах тухайн цаг үеийн аспектиг буюу нэр дэвшигчдэд өгөх үнэлгээ болон улс төрийн тулгамдсан маргаантай асуудлын талаарх байр суурийг тусгасан байдаг. Эдгээр харилцан адилгүй хүчин зүйлийг хослуулснаараа хувь хүний сэтгэл зүйг үндэс болгосон загвар нь сонгуулийн шийдвэр гаргах цогц үйл явцыг онолын өндөр түвшинд тусгахад шаардлагатай нөхцөлийг бүрдүүлсэн байдаг.

Рациональ сонголтын хандлагын шинжилгээ нь эдийн засгийн үр ашигтай, оновчтой байх онолоос хөгжиж гарч ирсэн. Сонгогчид улс төрийн нам, нэр дэвшигчдээс сонголт хийх эцсийн мөчид саналынхаа өөрт ирэх ашиг тус, үнэ цэнийг бодож сонголт хийдэгт оршино. Рациональ сонголтын хандлага (А. Даунс¹⁸, Р.Далтон¹⁹) нь АНУ-ын судлаач Э.Даунсын “Ардчиллын эдийн засгийн онол²⁰” хэмээх бүтээлд тусгалаа олсон байдаг. Энэхүү арга зам, хандлагаар сонгогч нь сонгуульд санал өгөхдөө үр ашгийн тооцоонд суурилдаг аж. Ингэхдээ тэрээр засгийн газрын өнгөрсөн бүрэн эрхийн хугацааны үйл ажиллагаанд үнэлэлт өгч одоогийн сөрөг хүчин засгийн эрхэнд байсан бол юу хийж чадах байсан гэдэгт харьцуулж үздэг. Үүний үндсэн дээр тэрээр өөрийнх нь хувийн зорилтуудыг хамгийн түрүүнд хэрэгжүүлж чадна гэж үзсэн намын төлөө саналаа өгдөг. Ийнхүү энэхүү хандлагаар сонгогчийн шийдвэр эцсийн бүлэгт улс төрийн тулгамдсан асуудал, эрх баригч болон сөрөг хүчний дүр төрх, инфляцийн түвшин, ажилгүйчүүдийн тоо, эдийн засгийн өсөлт зэрэг үзүүлэлтээс хамаардаг бөгөөд нийгмийн байдал болон урт хугацааны турш өөрчлөгдөөгүй байсан намын

¹⁵ Campbell, A., Converse, P.E., Miller, W.E., & Stoke, D.E. The American voter. New York., 1960

¹⁶ Evans, J. Voters and Voting; An Introduction. London., 2004

¹⁷ Lewis-Beck, M., Jacoby, W. G., Norpoth, H., & Weisberg, H. The American voter revisited. University of Michigan Press., 2008

¹⁸ A. Downs. An Economic theory of democracy. New York., 1957

¹⁹ Dalton. R. Citizen politics: Public opinion and political parties in advanced industrial democracies. Washington., 2008

²⁰ A. Downs. An Economic theory of democracy. New York., 1957

талаарх байр суурь нь гол бус үүрэг гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл улс төрийн болон эдийн засгийн шийдвэрийг үндсэндээ ижил зарчмаар гаргадаг гэж үздэг. Энэ хандлагыг богино хугацааны элемент гэж нэрлэх тал ч бий. Энэ хандлага дээр нэг шүүмжлэл явдаг нь сонгогчид тухайн үеийнхээ ашгийг харснаас цаг хугацаагаараа алслагдсан хүсээгүй зүйлийг тооцоогүй байж болох бөгөөд үүгээрээ өөрийн харалган байдлыг харуулдаг гэжээ.

Өнгөрсөн зууны 80-аад оноос ардчилсан улс орнуудад иргэдийн улс төрийн үйл байдалд язгуур шинжтэй өөрчлөлт гарч эхэлсэн гэж үздэг. Сонгуулиас сонгуулийн хооронд намыг дэмжигчдийн тоо өөрчлөгдөх нь хэвийн үзэгдэл боловч энэ нь эхэн үедээ улс төрийг сонирхох иргэдийн тоо буурч байна гэсэн хандлагаа илэрч байсан ч цаашдаа нам болон иргэдийн хоорондын холбоо суларч буйг илтгэх болж улмаар нийгэм дэх идэвхгүй сонгогчдын бүхэл бүтэн "арми"-ийг бий болгосон юм. Намыг тууштай дэмжигчдийн тоо цөөрөх үзэгдэл АНУ-д, Баруун Европт эхлэн ажиглагдсан байсан бол өнөөдөр энэ хандлага ардчилсан дэглэмтэй бүхий л улс орнуудыг хамарсан үзэгдэл болжээ. Энэ нь судлаачдаас сонгогчдын үйл байдлыг судлахдаа абсентизмын учир шалтгааныг тодруулахад илүү анхаарахыг шаардах болсон.

Abstract: In this article reviewed to make some analysis theoretical approaches of behaviorism. Its main purpose is to clarify the theories of behaviorism such as the theory of individual behaviorism & thoughts or feelings, the theory of cognitive in society, the theory of social supporting and social networks, explanation of micro-sociology & macro-sociology, approaches of social behavior, trends of rational options

НОМ ЗҮЙ:

1. Ц.Мөнхцэцэг. Сонгуулийн кампанийн коммуникаци (Монгол улсын жишээн дээр). УБ., 2009.
2. Аристотель. Улс төр. Орчуулсан Б.Даш-Ёндон. УБ., 2006.
3. Н.Макивелли. Эзэн хаан. Орчуулсан Д.Ганбат. УБ., 2011 он
4. Ш.Л.Монтескье. Хуулийн амин сүнс. Орчуулсан Т.Төмөрхүлэг. УБ., 2008 он
5. Улс төрийн шинжлэх ухаан. МУИС. Хамтын бүтээл. УБ., 2014.
6. Мира Б. Аги, Рейчел Карнийж. Зан үйлийн төлөвшил ба хүмүүсийн оролцоо. УБ., 2008.
7. Г.Лодой. Философи ба шинжлэх ухааны арга зүй. УБ., 2004.
8. Campbell, A., Converse, P.E., Miller, W.E., & Stoke, D.E. The American voter. New York., 1960
9. Evans, J. Voters and Voting: An Introduction. London., 2004
10. Lewis-Beck, M., Jacoby, W. G., Norpoth, H., & Weisberg, H. The American voter revisited. University of Michigan Press., 2000
11. A. Downs. An Economic theory of democracy. New York., 1957
12. Dalton. R. Citizen politics: Public opinion and political parties in advanced industrial democracies. Washington., 2008

²¹ Улс төрийн шинжлэх ухаан. МУИС. Улс төр судлалын тэнхим., 2010. 389 дахь тал